



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№43 /487/

2023.03.13

Цаг үе, үйл явдал

“ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ” ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН ЭХЭЛЛЭЭ



Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд зохион байгуулж ба хөдөөгийн хөгжлийг эрчимжүүлж, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, иргэдэд үзүүлж буй дэмжлэг, туслалцааг танилцуулах зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор “Хөдөөгийн сэргэлт” үндэсний чуулганыг зохион байгуулж байна.

Энэхүү чуулганд Монгол Улсын Засгийн газрын гишүүд, дэд сайд нарын төрийн удирдлагуудаас гадна төрийн болон төрийн бус байгууллагууд, 21 аймгийн удирдлагын баг, олон улсын байгууллагын төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагууд, орон нутгийн 1000 гаруй төлөөлөгч оролцож байна.

Чуулганы үеэр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Хот хөдөөгийн сэргэлт”, Шадар сайд

ажиллагаанууд болох юм. Мөн “Нээлттэй аймаг” өдөрлөгийн үеэр 21 аймаг өөрийн танилцуулга, “Хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа ажлуудынхаа талаар олон нийтэд танилцуулж байна.

Энэ үеэр бид Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяраас уг чуулганы талаарх сэтгэгдлийг нь сонирхлоо.

Тэрбээр “Хөдөөгийн сэргэлт” үндэсний чуулганы ач холбогдол аль нэг салбараар хязгаарлагдахгүй өргөн цар хүрээтэй юм. Монгол Улс маш том газар нутагтай, цөөн хүн амтай. Манай Батлан хамгаалах салбар бол нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг, хөдөө орон нутагт маш олон анги байгууллагатай томоохон салбар. Энэ том газар нутгийг хэрхэн хамгаалах вэ гэдэг асуудлын хүрээнд бид хөдөө орон нутагт байрлах Зэвсэгт хүчний анги салбаруудаа бэхжүүлэх, тэнд ажиллаж, амьдарч байгаа боловсон хүчнээ чадавхжуулах,

шаардлагатай тохиолдолд зарим анги байгууллагыг хөдөө орон нутагт шилжүүлэх ажлыг хийнэ. Мэдээж хүн амын үлэмж хэсэг нь оршин сууж байгаа нийслэлийнхээ аюулгүй байдлыг орхигдуулахгүй. Энэ ажлыг урт хугацааны туршид буюу тав, арван жил, цаашдаа

хүчний хэмжээнд арваад барилга инженерийн цэргийн анги байна. Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагчид нь тайван цагт улс орны хөгжил дэвшил, стратегийн бүтээн байгуулалтад бодитой хувь нэмэр оруулах хуультай орон. Энэ хүрээнд хөдөө орон



тогтвортой хөгжлийн бодлогын дагуу шийдэгдэнэ. “Хөдөөгийн сэргэлт” бол Засгийн газрын маш дэвшилттэй, далайцтай бодлогын асуудал. Иймээс салбар болгон үүн дээр бодлого боловсруулж байгаа. Манай салбарын хувьд бодлого нь тодорхой болсон. Одоо үүнийгээ

нутагт байрлаж байгаа анги салбаруудаа тухайн орны дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажилд оролцуулна. Аймаг орон нутгийн удирдлагаас санал санаачилга их ирж байна. Өмнөговь, Сүхбаатар, Говь-Алтай, Ховд зэрэг аймгуудад



дэс дараатайгаар хэрэгжүүлнэ.

Бид “Хөдөөгийн сэргэлт” бодлогын хүрээнд хэрэгжүүлэх бодлогоо тодорхойлчихсон, хэрэгжилтийнхээ төлөвлөлтийг хийчихсэн. Салбарын хэмжээний асуудал ярихаасаа илүү улс орны хэмжээний ажилд дэмжлэг үзүүлэх боломж гэж харж байгаа. Зэвсэгт

хийх ажил их байна. Ялангуяа, иргэдийг орон сууцжуулах, дэд бүтэц, дулааны станц, эрчим хүчний чиглэлийн ажлуудад Зэвсэгт хүчний алба хаагчдыг татан оруулж, зохион байгуулалтад оруулж, дэмжлэг үзүүлнэ” гэж санал бодлоо хуваалцлаа.



бөгөөд Эдийн засгийн хөгжлийн Сайд Ч.Хүрэлтбаатар “Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан “Монгол Улсын Засгийн газраас гаргаж буй бодлого, шийдвэрүүд”, Сангийн сайд Б.Жавхлан “Төвлөлийг сааруулах хүрээнд Засгийн Засгийн газрын дэмжлэгтэйгээр олгогдох дэмжлэгүүд” зэрэг илтгэлүүдийг хэлэлцүүлэх бөгөөд үдээс хойш “Бүсийн хөгжил-хамтын ажиллагаа”, “Шилжилт хөдөлгөөн ба залуусын манлайлал”, TEDx - Улаанбаатар”, “FUCKUP NIGHT” зэрэг үйл

тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, алслагдсан орон нутаг гэдэг угтаар нь цалингийн зэрэглэлийг ялгавартай, ахиу тогтоох, нийгмийн хамгааллын асуудалд нь дэмжлэг үзүүлэх, туслах аж ахуй, үйлдвэрлэл эрхлэхэд нь туслах, газар тариалан, хүнсний ногоо, мод бут тарих, тариалахыг нь бүхий л талаар дэмжих, боловсролыг нь дээшлүүлэх зэрэг асуудлыг салбарын хэмжээнд шийдвэрлэхийг зорин ажиллаж байгаа.

Түүнээс гадна Улаанбаатар цэргийн хүрээний ангиудад үүрэг чиглэл, ач холбогдлынх нь зэрэглэлээр үнэлгээ хийж, хүн амын нягтрал ихтэй газруудаас шилжүүлэн байршуулах,



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-3	-18


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	27

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,529	3,534
EUR	3,755	3,770
CNY	507.50	509.50
RUB	45.10	45.50
JPY	26	26.30
KRW	2.70	2.72

ЗУРХАЙ



2023.03.13 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 21

ХАВРЫН ТЭРГҮҮН ХӨХ БАР САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ЦАГААН МОРЬ ӨДӨР

ҮС ЗАСУУЛБАЛ:
Эд малын гарлагатай
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
07.10-18.53
Барилдлага:
Үл тохирох
Шүтэн барилдлага:
Өтлөх үхэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр эд эдлэл барагдах, хулгай, дээрмийг дарах тэргүүтэнд махаши тэнгэрээс гаслан ирэх тул хэрэг тус үл бүтнэ, эд хураах, номын өглөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн. Зүүн нүд татвал хувцас олодох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 681,212,510

Эдгэрсэн

Нийт: 654,132,455

Нас барсан

Нийт: 6,809,882

Цаг үе, үйл явдал

ШИНЭЭР ТОМИЛОГДСОН ОХУ-ЫН ЦЭРЭГ, АГААРЫН ЦЭРГИЙН АТТАШЕ ХОШУУЧ ГЕНЕРАЛ П.В.ПЕТРУНИНЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ өнөөдөр ОХУ-ын Элчин сайдын яамны дэргэдэх Цэрэг, агаарын цэргийн атташегаар шинээр томилогдсон хошууч генерал Павел Владимирович Петруниныг хүлээн авч уулзлаа.

Хурандаа Б.Бат-Эрдэнэ хошууч генерал П.В.Петруниныг томилогдсон явдалд баяр хүргэж, хоёр улсын хооронд тогтоосон цэрэг,

цэрэг-техникийн хамтын ажиллагаа амжилттай хэрэгжиж байгааг онцлов.

Мөн энэхүү уулзалтын үеэр албан үүргээ гүйцэтгэж дуусаад нутаг буцаж байгаа хурандаа Павел Григорьевич Анисовт сүүлийн гурван жилийн хугацаанд хоёр улсын цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны арга хэмжээнүүдийн амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэн ажилласанд

талархал илэрхийлсэн юм.

Уулзалтын төгсгөлд Батлан хамгаалахын сайдын тушаалаар хоёр улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж, хурандаа П.Г.Анисовыг "Цэргийн хамтын ажиллагааны төлөө" хүндэт тэмдгээр шагнаж, цаашдынх нь ажил, амьдралд амжилтын дээдийг хүсэн ерөөлөө.

ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 234 ДҮГЭЭР АНГИД АЖИЛЛАЛАА



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал энэ сарын 09-ний өдөр Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 234 дүгээр ангид ажиллалаа.

Командлагч усчин дайчдын 2022 оны гүйцэтгэл, 2023 оны зорилго, зорилтын хэрэгжилтийн талаар ангийн захирагч хурандаа Г.Эрдэнэбаярын өгсөн мэдээллийг сонссоны дараа ангийн штабын болон цэргийн байр, номын сан, соёлын төв, уурын зуух, спорт заал, гал тогоо, зэвсэглэл, цэргийн техник, усчин дайчдын гол багаж хэрэгслүүдтэй танилцав.

Үргэлжлүүлэн бие бүрэлдэхүүнд штабын бэлтгэлжилт, бэлэн байдал, цэргийн сургалт бэлтгэл, нийгмийн хамгаалал, алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлага, хөдөлмөр хамгаалал зэрэг сэдвээр үүрэг чиглэл өгсөн юм.

Тэрээр үүрэг, чиглэлийнхээ төгсгөлд усчин дайчдыг сахилга,

хариуцлагаа улам сайжруулж, үүрэг гүйцэтгэх чадвараа нэмэгдүүлэх сургалт, бэлтгэлүүдийг түлхүү явуулах хэрэгтэй. Бүтээлч санаачилга өндөр, харилцаа хандлага зэрэг, дэг журамтай газар ажил урагшилдаг учир цэргийн гэрээт албаны байлдагчаасаа эхлээд захирагч хүртлээ анги, байгууллагаа улам сайхан өнгө төрхтэй, бэлэн байдал, бэлтгэлжилтээ дээшлүүлэхэд анхаараарай. Ингэхдээ хөдөлмөр аюулгүй байдлын зааварчилгааг ягштал мөрдөж ажиллахыг сануулж байсан юм.

Ташрамд дурдахад, Зэвсэгт хүчиндээ төдийгүй Монгол Улсдаа цор ганц Гүүр, ус гатлалтын тусгай батальон гэдгээрээ алдартай тус анги нь Батлан хамгаалахын сайдын тушаалаар 1981 оны 5 дугаар сарын 20-ны өдөр "Десант ус гатлалтын тусгай батальон" нэртэйгээр байгуулагдсан түүхтэй юм.

Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ

БУУДЛАГЫН ТӨРӨЛД БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ ДЭД БАЙРТ ШАЛГАРАВ



Цогцолбор тэмцээнд БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалууд, ХХЕГ, ОБЕГ, ЦЕГ, Дотоодын цэргийн штаб, Тагнуулын Ерөнхий газар, ШШГЕГ, ТТХГ зэрэг 14 байгууллагын 13 багийн 100 гаруй удирдах бүрэлдэхүүн буудлага, биллиард, гар бөмбөг гэсэн гурван төрлөөр өрсөлдөж байгаа юм. Биллиардын тэмцээний тэргүүн байрт ХХЕГ, дэд байрт ЗХЖШ, гутгаар байрт Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын удирдлагууд шалгарсан бол буудлагын тэмцээний "АКМ" бууны төрөлд Хуурай замын цэргийн штабын дарга, хурандаа Ц.Буяндэлгэр мөнгөн медаль хүртэв.

Буудлагын тэмцээн ПМ, АКМ, СВД гэсэн төрлүүдээр явагдсан бөгөөд багийн дүнгээр тэргүүн байрт Дотоодын цэргийн штаб, дэд байрт Батлан хамгаалах яам, гутгаар байрт ХХЕГ-ын удирдлагууд шалгарчээ. 3 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд гар бөмбөгийн тэмцээн явагдаж, аваргуудаа тодруулна.



"Монгол цэргийн өдөр", Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойг тохиолдуулан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагуудын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг "Бидний нөхөрлөл" цогцолбор тэмцээн энэ сарын 7-ны өдөр эхэллээ.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлагуудын нэгдмэл үйл ажиллагаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх, бие бялдрын бэлтгэлжилт, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилготой тус тэмцээнийг энэ жил Хил хамгаалах Ерөнхий газраас зохион байгуулж байна.

"МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ИЙГ УГТАЖ ...



"Монгол цэргийн өдөр", Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жил, Хил хамгаалах байгууллагын түүхт 90 жилийн ойг тохиолдуулан Дорнод аймаг дахь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулдаг уламжлалт урлаг,

спортын цогцолбор тэмцээн энэ сарын 9-ний өдөр эхэллээ.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын 600 гаруй алба хаагч урлаг, спортын 16 төрлөөр 3 дугаар сарын 17-ны өдөр хүртэл өрсөлдөж шилдгүүдээ тодруулах юм. Арга хэмжээний эхэнд Дорнод

аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн эрхэм офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны байлдагч, ажилтан албан хаагчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид, Дорнод аймгийн

ард иргэддээ удахгүй болох "Монгол цэргийн өдөр", Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 102 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж тэмцээнд нь амжилт хүссэн юм.



ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ, ХҮМҮҮЖЛИЙГ ТҮГЭЭСЭЭР БАЙНА



"Монгол цэргийн өдөр", Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жил, ангийнхаа 50 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний 167 дугаар ангийнхан иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, цэрэг эх оронч үзэл хүмүүжил олгох сургалт, нөлөөллийн ажлыг шат дараатай зохион байгуулсаар байна.

Тухайлбал, энэ сарын 7-ны өдөр Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг урьж Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчиллаа. Ахлах ангийн сурагчдыг Монгол Улсын Төрийн далбааг мандуулах ёслолоор угтаж, хугацаат албаны дайчдын жагсаалын үзүүлэх тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолтыг сонирхуулав. Үргэлжлүүлэн "Орчин цагийн Зэвсэгт хүчний түүхийн жим", "Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг дэмжих

ажиллагаа дахь оролцоо", "Бидний мэргэжил бидний бахархал" зэрэг сэдвийн хүрээнд ахмад Э.Гансүх, ахмад Э.Эрболд нар мэдээлэл өгч, авьяаслаг хугацаат цэргийн алба хаагчид урлагийн тоглолтоо өргөн бариллаа.

Сурагчаас ч мөн талархлаа илэрхийлж цэргийн ах эгч нар, хугацаат цэргийн алба хаагчдад ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн юм.

Түүнчлэн сурагчид цэргийн байр, Алдрын танхимаар зочилж, цэрэгжлийн буухиа тэмцээнээр өрсөлдөв. 10 баг өрсөлдсөнөөс тэргүүн байрт 7 дугаар сургуулийн сурагч Н.Мягмарбаатар, дэд байрт 5 дугаар сургуулийн сурагч Н.Анхбаяр, гутгаар байрт 4 дүгээр сургуулийн сурагч А.Энх-Амгалан ахлагчтай багууд шалгарч, сурагчид цэргийн албаар бахархал дүүрэн буцсан юм.

Дарга дэд хурандаа
САЙНБОЛДЫН УУГАНБААР

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" редакц
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)